



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/101/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: vheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	13
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв:	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2. Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЕРӨӨ СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Д.ТУУЛ
ТАНАА

2025-02-25 № СЭА-2025/101/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус цэцэрлэг нь аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 57,497.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 15,537.1 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж,

зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Данс	Балансын зүйл	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	248,019,342.11	329,808,932.22
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	167,184,140.41	242,874,525.04
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	167,184,140.41	242,874,525.04
3121	Төгрөг	167,184,140.41	242,874,525.04
31211	Төрийн сангийн харилцах	167,184,140.41	242,874,525.04
33	АВЛАГА		59,225.48
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		59,225.48
35	БАРАА МАТЕРИАЛ	80,835,201.70	86,875,181.70
351	Түүхий эд материал		660,000.00
3511	Тусгай зориулалттай материал		660,000.00
354	Хангамжийн материал	80,835,201.70	86,215,181.70
3541	Бичиг хэргийн материал	49,500.00	767,500.00
3542	Аж ахуйн материал	67,775,481.70	67,630,981.70
3543	Сэлбэг хэрэгсэл	120,000.00	
3546	Хүнсний материал	3,361,220.00	1,660,700.00
3547	Бусад хангамжийн материал	9,529,000.00	16,156,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,364,155,565.60	3,203,334,094.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,364,155,565.60	3,203,334,094.00
392	Биет хөрөнгө	3,350,075,565.60	3,189,254,094.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,349,899,980.00	3,200,958,080.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-151,126,537.59	-171,972,923.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,125,110.00	93,981,687.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-42,169,148.74	-10,350,400.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,941,874.00	90,415,210.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,934,217.87	-29,603,146.33
39209	Зам, гүүрийн байгууламж	48,138,800.10	42,811,200.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,200,775.10	-42,811,200.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,718,400.00	22,718,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,355,772.70	-6,896,562.94
39217	Ном	2,037,853.50	3,750.00
393	Биет бус хөрөнгө	14,080,000.00	14,080,000.00
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	-250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,080,000.00	14,080,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,612,174,907.71	3,533,143,026.22
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,612,174,907.71	3,533,143,026.22

51	Засгийн газрын хувь оролцоо	3,612,174,907.71	3,533,143,026.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	215,688,467.50	215,688,467.50
51101	Өмч: - төрийн	215,688,467.50	215,688,467.50
512	Хуримтлагдсан үр дүн	3,214,861,352.01	3,135,829,470.52
5121	Өмнөх үеийн үр дүн	3,214,861,352.01	3,214,861,352.01
5122	Тайлант үеийн үр дүн		-79,031,881.49
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	181,625,088.20	181,625,088.20
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,612,174,907.71	3,533,143,026.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,982,127,383.25	1,230,609,821.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,065,654,441.00	84,404,920.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,065,654,441.00	84,404,920.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,053,442,573.00	84,404,920.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	12,211,868.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	916,472,942.25	1,146,204,901.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	807,269,900.00	1,066,857,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	807,269,900.00	1,066,857,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,005,800.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,005,800.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,197,242.25	79,347,701.56
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	100,197,242.25	79,347,701.56
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	809,898,748.40	1,185,487,736.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	809,898,748.40	1,185,487,736.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	800,892,948.40	1,175,288,636.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	485,241,458.95	750,481,542.79
210101	Үндсэн цалин	371,287,240.65	497,812,146.00
210102	Нэмэгдэл	90,759,333.80	223,859,956.79
210104	Урамшуулал	23,194,884.50	28,809,440.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,038,597.88	94,194,717.30
210201	Тэтгэврийн даатгал	43,134,991.25	60,680,451.48

210202	Тэтгэмжийн даатгал	4,813,706.25	11,942,650.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,131,574.56	4,307,881.39
210204	Ажилгүйдлийн даатгал	897,334.78	3,052,193.38
210205	Эрүүл мэндийн даатгал	9,060,991.04	14,211,540.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,926,732.78	76,153,101.56
210301	Гэрэл, цахилгаан	12,127,412.78	15,592,944.76
210302	Түлш, халаалт	84,712,320.00	59,570,156.80
210303	Цэвэр, бохир ус	1,087,000.00	990,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,886,750.00
210401	Бичиг хэрэг		2,886,750.00
2105	Нормативт зардал	80,761,300.00	95,618,720.00
210502	Хоол, хүнс	80,761,300.00	95,618,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,976,100.00	3,194,600.00
210604	Урсгал засвар	3,976,100.00	3,194,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,370,000.00	1,455,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,370,000.00	1,455,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,578,758.79	151,304,204.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,447,682.00	20,351,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,154,000.00	4,308,299.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,977,076.79	126,644,425.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,005,800.00	10,199,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,005,800.00	10,199,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,005,800.00	10,199,100.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,172,228,634.85	45,122,085.10
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,211,868.00	124,153,966.59
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		124,153,966.59
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	12,211,868.00	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-12,211,868.00	-124,153,966.59
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,160,016,766.85	-79,031,881.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	916,472,942.25	1,146,204,901.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,000,000.00
122	Тусламжийн орлого		1,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/		1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	916,472,942.25	1,145,204,901.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	807,269,900.00	1,065,857,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	807,269,900.00	1,065,857,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,005,800.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,005,800.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,197,242.25	79,347,701.56
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	100,197,242.25	79,347,701.56
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	764,516,699.08	1,064,942,516.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	764,516,699.08	1,064,942,516.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	755,510,899.08	1,054,843,416.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	484,258,030.95	750,298,468.27
210101	Үндсэн цалин	370,303,812.65	497,629,071.48
210102	Нэмэгдэл	90,759,333.80	223,859,956.79
210104	Урамшуулал	23,194,884.50	28,809,440.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,639,597.88	94,194,717.30
210201	Тэтгэврийн даатгал	42,735,991.25	65,023,364.48
210202	Тэтгэмжийн даатгал	4,813,706.25	7,599,737.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,131,574.56	4,307,881.39
210204	Ажилгүйдлийн даатгал	897,334.78	3,015,393.38
210205	Эрүүл мэндийн даатгал	9,060,991.04	14,248,340.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,338,142.25	76,153,101.56

210301	Гэрэл, цахилгаан	9,538,822.25	15,592,944.76
210302	Түлш, халаалт	84,712,320.00	59,570,156.80
210303	Цэвэр, бохир ус	1,087,000.00	990,000.00
2105	Нормативт зардал	79,454,400.00	93,971,500.00
210502	Хоол, хүнс	79,454,400.00	93,971,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,859,100.00	3,194,600.00
210604	Урсгал засвар	4,859,100.00	3,194,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,370,000.00	1,570,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,370,000.00	1,570,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,591,628.00	35,461,029.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,437,628.00	25,364,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,154,000.00	10,096,699.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,005,800.00	10,099,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,005,800.00	10,099,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,005,800.00	10,099,100.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	151,956,243.17	81,262,384.63
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		5,572,000.00
	Дотоод эх үүсвэрээр		5,572,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		5,572,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-5,572,000.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	151,956,243.17	75,690,384.63
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		167,184,140.41
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		242,874,525.04

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	3,214,861,352.01	3,612,174,907.71
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			-79,031,881.49	-79,031,881.49
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	3,135,829,470.52	3,533,143,026.22

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,314,634,800.00	1,070,514,516.93	244,120,283.07	81.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,314,634,800.00	1,070,514,516.93	244,120,283.07	81.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,304,535,700.00	1,060,415,416.93	244,120,283.07	81.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	952,430,600.00	750,298,468.27	202,132,131.73	78.8
210101	Үндсэн цалин	666,612,400.00	497,629,071.48	168,983,328.52	74.7
210102	Нэмэгдэл	268,143,200.00	223,859,956.79	44,283,243.21	83.5
210104	Урамшуулал	17,675,000.00	28,809,440.00	-11,134,440.00	163.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,832,100.00	94,194,717.30	15,637,382.70	85.8
210201	Тэтгэврийн даатгал	74,688,100.00	65,023,364.48	9,664,735.52	87.1
210202	Тэтгэмжийн даатгал	8,784,300.00	7,599,737.45	1,184,562.55	86.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,393,200.00	4,307,881.39	85,318.61	98.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,393,200.00	3,015,393.38	1,377,806.62	68.6
210205	Эрүүл мэндийн даатгал	17,573,300.00	14,248,340.60	3,324,959.40	81.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,123,500.00	76,153,101.56	1,970,398.44	97.5
210301	Гэрэл, цахилгаан	12,435,100.00	15,592,944.76	-3,157,844.76	125.4
210302	Түлш, халаалт	64,363,000.00	59,570,156.80	4,792,843.20	92.6
210303	Цэвэр, бохир ус	1,325,400.00	990,000.00	335,400.00	74.7
2105	Нормативт зардал	110,693,800.00	93,971,500.00	16,722,300.00	84.9
210502	Хоол, хүнс	110,693,800.00	93,971,500.00	16,722,300.00	84.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,194,600.00	275,400.00	92.1
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,194,600.00	275,400.00	92.1
2107	Томилолт, зочны зардал				

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,488,400.00	1,570,000.00	1,918,400.00	45.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,488,400.00	1,570,000.00	1,918,400.00	45.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,497,300.00	41,033,029.80	5,464,270.20	88.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,395,700.00	30,936,330.00	5,459,370.00	85.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,101,600.00	10,096,699.80	4,900.20	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,099,100.00	10,099,100.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,099,100.00	10,099,100.00		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,099,100.00	10,099,100.00		100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
	Дотоод эх үүсвэрээр ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
1	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,314,634,840.41	1,146,204,901.56	-979,020,761.15	
131	Улсын төсвөөс санхүүжих	1,065,857,200.00	1,066,857,200.00	-899,673,059.59	
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,065,857,200.00	1,066,857,200.00	1,066,857,200.00	
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	167,184,140.41		167,184,140.41	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,593,500.00	79,347,701.56	-79,347,701.56	
132001	Орон нутгийн төсвөөс	81,593,500.00	79,347,701.56	-79,347,701.56	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		167,184,140.41	-167,184,140.41	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		242,874,525.04	-242,874,525.04	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг нь “2-5 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан асрах, хамгаалах, хөгжүүлэх, төлөвшүүлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн зорилт тавьж ажилласан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Цэцэрлэг нь үйл ажиллагаандаа хүүхдийн хөгжих, эсэн мэнд амьдрах, хамгаалагдах, оролцох эрхийг хүндэтгэх, хүүхэд бүрд боловсрол эзэмших тэгш боломж олгох, тэдний онцлог, ялгаатай байдлыг харгалзах, хүндэтгэлтэй хандах ;

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,031.9 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	167,184.1	242,874.5	75,690.4
Авлага	-	59.2	59.2
Бараа материал	80,835.2	86,875.2	6,040.0
Үндсэн хөрөнгө	3,364,155.6	3,203,334.1	(160,821.5)
Нийт хөрөнгө	3,612,174.9	3,533,143.0	(79,031.9)
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,612,174.9	3,533,143.0	(79,031.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,612,174.9	3,533,143.0	(79,031.9)

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 242,874.5 мянган төгрөг болж 75,690.4 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9¹-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Авлага дансанд төлбөр тооцоог хянаагүйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн 59.1 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 86,875.2 мянган төгрөг болж 6,040.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 124,359.2 мянган төгрөгийн

¹ Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 118,319.2 мянган төгрөгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,465,218.3 мянган төгрөг болж 132,973.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 5,572.0 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 57,497.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аймгийн Боловсролын газраас 8,500.0 мянган төгрөгийн техник хэрэгсэл, зөөврийн компьютер, ААН иргэдээс 18,407.9 мянган төгрөгийн хандив зэрэг нийт 84,404.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, Ерөө сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 140 дугаар тогтоолоор цаашид ашиглах боломжгүй, элэгдлээ бүрэн нөхсөн 222,950.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан з нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 261,884.2 мянган төгрөг бөгөөд 3,203,334.1 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 756,208.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 81,593.5 мянган төгрөг, нийт 837,802.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 265,362.2 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 5,563.3 мянган төгрөгөөр нийт 278,745.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хүүхдийн хоолны зардлыг 34,654.9 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,511.9 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 101,974.3 мянган төгрөгөөр нийт 138,141.1 мянган төгрөгөөр бууруулж төсвийг 978,406.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,065,857.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 81,593.5 мянган төгрөгийн, оны эхний үлдэгдлээс 167,184.1 мянган төгрөгөөр нийт 1,314,634.8 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 292,821.1 мянган төгрөгөөр,
- Хүүхдийн хоолны зардлыг 15,793.7 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 3,488.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 14,025.9 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 10,099.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн гэх мэт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,314,634.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,070,514.5 мянган төгрөгийг зарцуулж, 242,874.5 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,070,514.5 мянган төгрөг буюу 81.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	71802- Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,330.6	2,325.0	(5.6)	99.8
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	110,693.8	93,971.5	(16,722.3)	84.9
		3	81816- Зөв монгол хүүхэд	4,133.3	4,130.0	(3.3)	99.9
		4	81823- Боловсролын багшийн сургалт	2,330.6	350.0	(1,980.6)	15.0
		5	81834- Боловсролын стандарт сургалт	1,054,691.0	844,196.2	(210,494.9)	80.0
		6	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	32,024.9	32,024.8	(0.2)	100.0
		7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	81,593.5	79,347.7	(2,245.8)	97.2
		8	80233-Хүүхэд хамгаалал	1,542.5	1,528.0	(14.5)	99.1
		9	81832-Нүүдлийн бүлэгт хамруулах	25,294.6	12,641.4	(12,653.2)	50.0
		Нийт		1,314,634.8	1,070,514.5	(244,120.3)	81.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2024 оны анх батлагдсан төсвөөр/ хүүхдийн хоолны зардал 110,693.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж,

гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид *Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг гэх*/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 809,898.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,099.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл 1 удаа;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 1 удаа;
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1 удаа;

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр хүнсний материалыг Б.Элдэв

Очир, Б.Норовбанзад, С.Энхтөр нартай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит “ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 909 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс акт, албан шаардлагыг бүрэн биелүүлж, шилэн дансны цахим цэсэнд мэдээллийг хугацаанд нь мэдээлэх, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	220.9	2	220.9	100.0
Албан шаардлага	1	4,162.0	1	4,162.0	100.0
Зөвлөмж	2				
Нийт дүн	5	4,382.9	3	4,382.9	66.6

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 69,151.8 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үр дүнгийн тайланд 376.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан;
- Худалдан авсан 5,572.0 мянган төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлаар бүртгэсэн;
- Санхүүгийн программаар боловсруулсан тоо мэдээллийг хянаагүйгээс санхүүгийн тайланд тайлант үеийн үр дүнг 63,203.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 6,683.3 мянган төгрөгийн зөрчил² илэрч 2,563.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,120.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлээ.

5.1 АЛБАН ШААРДЛАГА

1.Цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар нэр бүхий 7 багш, ажилтныг 1,222.8 мянган төгрөгөөр, 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/39 дүгээр тушаалаар 2 багш, ажилтныг 1,340.5 мянган төгрөгөөр эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, хамт олноо манлайлсан гэх үндэслэлээр шагнах шийдвэр гаргаж, цалингийн батлагдсан төсвөөс шагналын зардалд нийт 2,563.3 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх,

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.1 **Илрүүлэлт:** Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 4,120.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 **Өгсөн зөвлөмж:** Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ҮХ элэгдлийн зардлыг санхүүгийн тайланд дутуу тусгасан	1	376.5			1	376.5	1	376.5				
Худалдан авсан ҮХ-ийг МГ тайланд бараа материалын зардлаар тусгасан	1	5,572.0			1	5,572.0	1	5,572.0				
Тайлант үеийн үр дүнг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн	1	63,203.3			1	63,203.3	1	63,203.3				
Дүн	3	69,151.8			3	69,151.8	3	69,151.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй	1	2,563.3			1	2,563.3						
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	4,120.0					1	4,120.0				
Дүн	2	6,683.3			1	2,563.3	1	4,120.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагаатай холбоотой.	1				1			
Дүн	1				1			
Нийт дүн	2				2			